



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

ТА ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХЫН ӨМНӨ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БОЛОН НУУЦЛАЛЫН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТОХИОЛДОЛД **“ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ”** ГЭСЭН ТОВЧИЙГ ДАРНА УУ. ХЭРЭВ ТА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХГҮЙ БАЙГАА БОЛ **“ТАТГАЛЗАХ”** ТОВЧИЙГ ДАРЖ СИСТЕМЭЭС ГАРНА УУ.

Энэхүү “Стор пэй” үйлчилгээний нөхцөлийг МУ-ын Иргэний хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох дүрэм, журам болон бусад хууль тогтоомжийг үндэслэн Монгол Улсад бүртгэлтэй “Стор пэй ББСБ” ХХК (ГХО) /цаашид “Компани” гэх/ болон иргэн /цаашид “хэрэглэгч” гэх/ нарын хооронд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийг “Стор пэй” аппликейшн /цаашид “аппликейшн” гэх/-ээр дамжуулан хуваарийн дагуу хуваан төлөх үйлчилгээг хэрэглэгчид үзүүлэхтэй холбогдсон харилцаанд баримтлах бөгөөд компани хэрэглэгч таны хувийн мэдээллийг хүлээн авах, цуглуулах, ашиглах, боловсруулах, хадгалах, дамжуулах болон биометрик мэдээлэл буюу царай дүрсийг уг үйлчилгээний нөхцөлд заасан зорилгоор ашиглах, түүнд боловсруулалт хийх, улмаар худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх үйлчилгээний эрхийг олгох эрх зүйн үр дагавар бүхий хэлцэл болно.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Компани нь үйлчилгээг илүү боловсронгуй болгох зорилгоор үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхийг дангаар эдлэх бөгөөд уг өөрчлөлтийн талаар хэрэглэгчийн бүртгүүлсэн цахим шуудан болон аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд мэдэгдэнэ. Хэрэглэгч шинэчлэгдсэн үйлчилгээний нөхцөлтэй танилцан хүлээн зөвшөөрч баталгаажуулснаар үйлчилгээг үргэлжлүүлэн ашиглах боломжтой.
- 1.2. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлд орсон өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор энэ талаараа customer_voice@storepay.mn цахим хаягаар мэдэгдэх ба Үйлчилгээний нөхцөл өөрчлөгдөхөөс өмнө ашигласан үйлчилгээг тухайн үеийн нөхцөлөөр ашиглаж дуусгана. Зөвшөөрөөгүй тохиолдолд шинэ үйлчилгээ авах, нэмж худалдан авалт хийх боломжгүй байна.
- 1.3. Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. **“Стор пэй аппликейшн”** гэж хэрэглэгчийн ухаалаг гар утас, бусад төхөөрөмжид татан авч, Компанийн санал болгож буй үйлчилгээнээс сонгон авах зориулалт бүхий аппликейшныг хэлнэ.
 - 1.3.2. **“Хэрэглэгч”** гэж Стор пэй аппликейшныг татаж хэрэглэгчээр бүртгүүлэхээр хүсэлт илгээсэн, компанийн дотоод дүрэм, журмын шаардлага хангасан, үйлчилгээний эрх нээсэн, Цахим мөнгөний гэрээ байгуулсан, Монгол Улсын иргэн, 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай этгээдийг хэлнэ.
 - 1.3.3. **“Цахим мөнгөний гэрээ байгуулаагүй хэрэглэгч”** гэж Стор пэй аппликейшнд бүртгэл үүсгэсэн бөгөөд Цахим мөнгөний гэрээ байгуулахгүйгээр Стор пэй аппликейшныг ашиглаж буй этгээдийг;
 - 1.3.4. **“Мерчант”** гэж худалдаалж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд худалдан борлуулах, үйлчилгээ үзүүлж хамтран ажиллахаар Компанитай гэрээ байгуулсан, хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээтэй Монгол улсын иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

- 1.3.5. **“Үйлчилгээний эрх”** гэж хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээлэлд тулгуурлан компаниас санал болгож буй үйлчилгээнд ашиглах зориулалт бүхий системээс тооцоолон гаргасан төгрөгөөр илэрхийлэх дүнг хэлнэ.
- 1.3.6. **“Хэрэглэгчийн түвшин”** гэж аппликейшнээр дамжуулан үйлчилгээний нөхцөлийн дагуу хэрэглэгчийн худалдан авалтын түүхэд суурилан санал болгож буй худалдан авалтын ялгамжтай боломжийг хэлнэ.
- 1.3.7. **“Биометрик мэдээлэл”** гэж хэрэглэгчийг танин баталгаажуулах, залилах болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй хэрэглэгчийн нүүр царайны бодит цагийн дүрс мэдээллийг хэлэх бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчийн өөрийнх нь ХУР системээс татуулсан зурагтай нь харьцуулан баталгаажуулна.
- 1.3.8. **“Баталгаажуулах үйлдэл”** гэж хэрэглэгч нь Компанид хандан аппликейшн дээр үйлчилгээний хүсэлт илгээх, эргэн төлөх болон бусад үйлдлийг хүлээн зөвшөөрснөө илэрхийлж буй хэрэглэгчийн үйлдлийг ойлгоно.
- 1.3.9. **“Контент”** гэж аппликейшн дээрх мэдээлэл, өгөгдөл, технологийн хэрэгсэл, код, хэв загвар, аппликейшн, санаа, ноу-хау, лого, бичвэр, дүрс, зураг, бичлэг, дизайн, бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдэл, шаардлага, сурталчилгааны материал болон тэдгээрт хэвлэгдсэн бүх төрлийн бичгийн болон мультимедиа материал зэрэг бүх контент хамаарна.
- 1.3.10. **“Торгууль”** гэж үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтын төлбөр төлөх үүргээ хугацаандаа буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд хэрэгжүүлэх хариуцлагын арга хэмжээ бөгөөд Компаниас хугацаа хэтрүүлсэн нэхэмжлэхийн үнийн дүнгээс хамаарч үйлчилгээний нөхцөлд урьдчилан ялгамжтай тогтоосон мөнгөн төлбөрийг хэлнэ.
- 1.3.11. **“Скоринг”** гэж хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээлэл, зээлжих зэрэглэлийн оноонд үндэслэн компанийн дотоод дүрэм, журам, аргачлалын дагуу худалдан авалтын эргэн төлөлтийн чадавхыг тодорхойлох үнэлгээг хэлнэ.
- 1.3.12. **“Gofresh үйлчилгээний эрх”** гэж “Премиум” /Premium/ болон “Гоулд” /Gold/ түвшний хэрэглэгчдэд санал болгож буй өдөр тутмын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг сонгогдсон мерчантуудаас худалдан авахдаа үндсэн эрхийн хэмжээнд нөлөөлөхгүйгээр ашиглах боломжтой нэмэлт эрхийг хэлнэ.
- 1.3.13. **“SPCFIN токен”** гэж компанийн гаргаж, BXYU-ээр дамжуулан нийтэд арилжаалсан, Binance Smart Chain-д суурилсан, BEP20 стандарт бүхий токен юм. Тухайн токеныг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан урамшуулал хэлбэрээр хэрэглэгчдэд олгох бөгөөд хэрэглэгч тухайлсан нөхцөлөөр Стор пэй үйлчилгээнд ашиглах боломжтой байна.
- 1.3.14. **“SPCFIN крипто хаяг”** гэж Хэрэглэгч бүртгэл үүсэхэд хэрэглэгчид стор пэй систем дээр үүсгэсэн дахин давтагдашгүй дугаарлалт бүхий орлого хүлээж авах, зарлага гаргах зориулалт бүхий крипто хаяг;
- 1.3.15. **“SPCFIN токен түгжих”** гэж хэрэглэгч худалдан авалтдаа SPCFIN токен оролцуулсан тохиолдолд үйлчилгээний нөхцөлд заасан хэмжээгээр SPCFIN крипто хаягаас зарлага гаргах үйлдлийг түр хязгаарлахыг хэлнэ.
- 1.3.16. **“Цахим мөнгө”** гэж Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгтэй адил үнэ цэн бүхий, мөнгөн дүн нь цахим хэлбэрээр хадгалагдах, төгрөгийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдэж, мөнгөн хөрөнгөд чөлөөтэй хөрвөх, бэлэн бус төлбөр тооцоонд ашиглагдах Компанийн гаргасан Storepay/Сторпэй нэртэй цахим мөнгийг;
- 1.3.17. **“Цахим хэтэвч”** гэж Хэрэглэгчийн нэр дээр үүсгэсэн, Стор пэй аппликейшн дээр харагдах, Storepay/Сторпэй цахим мөнгийг агуулж буй дахин давтагдашгүй дугаар бүхий дансыг;
- 1.3.18. **“Дахин хуваалт”** гэж хэрэглэгч өөрийн хугацаа хэтрэлтгүй, идэвхтэй худалдан авалтын төлөгдөөгүй төлөлтийн хуваарийг шинэчлэн, уртасгасан нөхцөлд шилжүүлэх шимтгэлтэй үйлчилгээг хэлнэ.

- 1.3.19. **“Шимтгэл”** гэж компаниас санал болгож буй тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигласны хариуд хэрэглэгчийн төлөхөөр тогтоосон төлбөрийг хэлнэ.

Хоёр. Үйлчилгээний нийтлэг нөхцөлүүд

- 2.1. Хэрэглэгч нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр эрх нээлгэх тохиолдолд сүүлийн 2 сараас дээш тасралтгүй төлсөн байх бөгөөд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байна.
- 2.2. **Үйлчилгээний эрхийн хэмжээ:** Компани нь хэрэглэгчээс ирүүлсэн хүсэлт, санхүүгийн болон хувийн мэдээлэлд үндэслэн батлагдсан нөхцөлийн дагуу үйлчилгээний эрхийг тооцоолж нээнэ.
- 2.2.1. Компани нь аппликейшнээр дамжуулан 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс 10,000,000 (арван сая) төгрөг хүртэлх худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх эрхийг хэрэглэгчид олгоно.
- 2.2.2. Хэрэглэгч Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр үйлчилгээний эрх нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд Компаниас 100,000 (нэг зуун мянга) төгрөгөөс 5,000,000 (таван сая) хүртэлх төгрөгийн худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх эрхийг хэрэглэгчид олгоно.
- 2.2.3. Хэрэглэгч өөрийн үйлчилгээний эрхийн хэмжээнээс давсан үнийн дүнтэй худалдан авалт хийж болох бөгөөд эрхийн хэмжээнээс давсан дүн нь эхний буюу урьдчилгаа төлөлт дээр нэмэгдэн тооцогдоно.
- 2.3. Хэрэглэгч өөрийн түвшнээс хамаарч дараах байдлаар худалдан авалтын төлбөрийг хуваан төлнө. Үүнд:
- 2.3.1. **“Энгийн” /Standard/** түвшний хэрэглэгчид үүсэх хуваан төлөх эрхийн дээд хэмжээ 3,000,000 төгрөг байх ба дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ. Үүнд:
- Үйлчилгээний эрхийн хэмжээнд 3 худалдан авалтыг давхардуулан авч ашиглах боломжтой;
 - Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
 - Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэх үүсгэж, үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
 - Худалдан авалтын төлбөрөө 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 45 (дөчин тав) хоногийн хугацаанд төлөх.
 - Хүнс болон эмийн сангаас худалдан авалт хийхдээ худалдан авалтын төлбөрөө 3 (гурав) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 30 (гуч) хоногийн хугацаанд төлөх;
 - Шимтгэлтэй бүтээгдэхүүн буюу худалдан авалтын төлбөрөө 8 (найм) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 105 (зуун тав) хоногийн хугацаанд төлөх;
 - Шимтгэлтэй бүтээгдэхүүн буюу худалдан авалтын төлбөрөө 10 (арав) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 135 (зуун гучин тав) хоногийн хугацаанд төлөх.
- 2.3.2. **“Премнум” /Premium/** түвшний хэрэглэгчид үүсэх хуваан төлөх эрхийн дээд хэмжээ 3,000,000 төгрөг байх ба дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ. Үүнд:
- Үйлчилгээний эрхийн хэмжээндээ хэдэн ч удаа давхардуулан ашиглах боломжтой.
 - Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
 - Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэх үүсгэж үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
 - **“Энгийн” /Standard/** түвшинд олгож буй бүх хуваан төлөлтийн сонголтыг ашиглах;
 - 2,000,000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтын 50 хувийг урьдчилж төлөөд, үлдэгдэл 50 хувийг 4 (дөрөв) хуваан 30 (гуч) хоногийн зайтайгаар 4 (дөрөв) сарын хугацаанд төлөх;

- Худалдан авалтын төлбөрөө урьдчилгаагүй 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 60 (жар) хоногийн хугацаанд төлөх;
 - Худалдан авалтын төлбөрөө урьдчилгаагүй 2 (хоёр) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 30 (гуч) хоногийн хугацаанд төлөх;
 - Худалдан авалтын төлбөрөө 3 (гурав) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 30 (гуч) хоногийн хугацаанд төлөх;
 - Gofresh үйлчилгээний эрх.
- 2.3.3. **“Гоулд” /Gold/** түвшний хэрэглэгчид үүсэх хуваан төлөх эрхийн дээд хэмжээ 5,000,000 төгрөг байх ба дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ. Үүнд:
- Үйлчилгээний эрхийн хэмжээндээ хэдэн ч удаа давхардуулан ашиглах боломжтой;
 - Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
 - Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэх үүсгэж үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
 - **“Премиум” /Premium/** түвшний хэрэглэгчид олгож буй бүх хуваан төлөлтийн сонголтыг ашиглах;
 - Худалдан авалтын төлбөрөө 6 (зургаа) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 75 (далан тав) хоногийн хугацаанд төлөх;
 - Gofresh үйлчилгээний эрх.
- 2.3.4. **“Платинум” /Platinum/** түвшний хэрэглэгчид үүсэх хуваан төлөх эрхийн дээд хэмжээ 8,000,000 төгрөг байх ба дараах худалдан авалтын боломжийг эдэлнэ.
- Үйлчилгээний эрхийн хэмжээндээ хэдэн ч удаа давхардуулан ашиглах боломжтой;
 - Худалдан авалтын төлбөрийг шууд төлөх;
 - Хүссэн үнийн дүнгээрээ худалдан авалтын төлбөрийн нэхэмжлэх үүсгэж үйлчилгээний эрхээ оролцуулан ашиглах;
 - **“Гоулд” /Gold/** түвшний хэрэглэгчид олгож буй бүх хуваан төлөлтийн сонголтыг ашиглах;
 - Gofresh үйлчилгээний эрх.
- 2.4. Хэрэглэгчийн түвшин дараах байдлаар нэмэгдэж, буурна. Үүнд:
- 2.4.1. Дараах тохиолдолд түвшин нэмэгдэнэ:**
- 2.4.1.1. **“Энгийн” /Standard/** түвшний хэрэглэгч хамгийн багадаа 2 удаагийн худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу төлбөрийн хуваарьт заасны дагуу хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгах мөн тухайн худалдан авалтуудын үнийн дүнгийн нийлбэр хамгийн багадаа 1,000,000₮ хүрсэн тохиолдолд **“Премиум” /Premium/** түвшний хэрэглэгч болно.
- 2.4.1.2. **“Премиум” /Premium/** түвшний хэрэглэгч хамгийн багадаа 3 удаагийн дараалсан худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу төлбөрийн хуваарьт заасны дагуу хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгах мөн тухайн худалдан авалтуудын үнийн дүнгийн нийлбэр хамгийн багадаа 2,000,000₮ хүрсэн тохиолдолд **“Гоулд” /Gold/** түвшний хэрэглэгч болно.
- 2.4.1.3. **“Гоулд” /Gold/** түвшний хэрэглэгч хамгийн багадаа 5 удаагийн дараалсан худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу төлбөрийн хуваарьт заасны дагуу хугацаа хэтрүүлэхгүй төлж дуусгах мөн тухайн худалдан авалтуудын үнийн дүнгийн нийлбэр хамгийн багадаа 5,000,000₮ хүрсэн тохиолдолд **“Платинум” /Platinum/** түвшний хэрэглэгч болно.

2.4.1.4. Бүх түвшний хэрэглэгчид худалдан авалтаа хугацаа хэтрэлтгүй төлсөн тохиолдолд тухайн худалдан авалтын үнийн дүнгээс хэрэглэгчийн түвшинд харгалзах дараах хувиар үйлчилгээний эрхийн хэмжээг нэмэгдүүлнэ.

- “Энгийн” /Standard/ түвшин - 10 хувь;
- “Премиум” /Premium/ түвшин – 12.5 хувь;
- “Гоулд” /Gold/ түвшин– 15 хувь;
- “Платинум” /Platinum/ түвшин – 17.5 хувь.

2.4.2. Дараах тохиолдолд түвшин буурна:

2.4.2.1. “Премиум” /Premium/ түвшний хэрэглэгч 2 худалдан авалт дараалан хугацаа хэтрүүлсэн эсхүл аль нэг худалдан авалтын төлбөрийг 14 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд уг түвшин буурч, “Энгийн” /Standard/ түвшин рүү шилжинэ.

2.4.2.2. “Гоулд” /Gold/ түвшний хэрэглэгч 2 худалдан авалт дараалан хугацаа хэтрүүлсэн эсхүл аль нэг худалдан авалтын төлбөрийг 14 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд уг түвшин буурч, “Премиум” /Premium/ түвшин рүү шилжинэ.

2.4.2.3. “Платинум” /Platinum/ түвшний хэрэглэгч 2 худалдан авалт дараалан хугацаа хэтрүүлсэн эсхүл аль нэг худалдан авалтын төлбөрийг 14 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд уг түвшин буурч, “Гоулд” /Gold/ түвшин рүү шилжинэ.

2.5. Хэрэглэгчийн үйлчилгээний эрх дараах байдлаар нэмэгдэж, буурна. Үүнд:

2.5.1. Дараах тохиолдолд үйлчилгээний эрх нэмэгдэнэ:

2.5.1.1. Худалдан авалтын төлбөрийг амжилттай буюу төлбөрийн хуваарьт заасны дагуу хугацаа хэтрүүлэхгүй төлж дууссан;

2.5.1.2. SPCFIN токены урамшууллаар буюу 4.1-т заасны дагуу эрхийн хэмжээ нэмэгдэнэ.

2.5.2. Дараах тохиолдолд үйлчилгээний эрх буурна:

2.5.2.1. Худалдан авалтын төлбөрийг хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хоног тутам үйлчилгээний эрхийн хэмжээ буурна.

2.6. Хэрэглэгч дараах тохиолдолд зайлшгүй скоринг дахин хийлгэж, үйлчилгээний эрхийг шинэчлэн тооцуулна. Үүнд:

2.6.1. Хуанлийн 90 хоногийн турш идэвхгүй байсан буюу шинээр худалдан авалт хийгээгүй;

2.6.2. Үйлчилгээний нөхцөлийн 7.8-д заасны дагуу рүйлчилгээний эрх нь хязгаарлагдаж сэргэсэн;

2.6.3. Хэрэглэгч өөрөө аппликейшн дээрээс Эрх дахин тооцуулах хүсэлт үүсгэх тохиолдолд;

2.7. Шимтгэлтэй хуваан төлөлтийн бүтээгдэхүүн:

2.7.1. Компани нь энэ бүлэгт заасан нэмэлт нөхцөлийн дагуу "Шимтгэлтэй хуваан төлөлтийн бүтээгдэхүүн" /цаашид "Шимтгэлтэй бүтээгдэхүүн" гэх/-ийг бүх түвшний хэрэглэгчид санал болгох бөгөөд хэрэглэгч уг бүтээгдэхүүнийг сонгон ашигласан тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлнө.

2.7.2. Шимтгэлтэй бүтээгдэхүүн нь дараах төрөлтэй байна:

2.7.2.1. Худалдан авалтын төлбөрөө 8 (найм) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 105 (зуун тав) хоногийн хугацаанд төлөх:

- Үйлчилгээний шимтгэл: Худалдан авалтын үнийн дүнгийн 6.99 хувь;
- Шимтгэлийг эхний төлөлттэй хамт төлснөөр худалдан авалт баталгаажна.
- Нэг удаагийн худалдан авалтын доод дүн: 1,000,000 (нэг сая) төгрөг.

2.7.2.1 Худалдан авалтын төлбөрөө 10 (арав) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 135 (зуун гучин тав) хоногийн хугацаанд төлөх:

- Үйлчилгээний шимтгэл: Худалдан авалтын үнийн дүнгийн 8.99 хувь;
- Шимтгэлийг эхний төлөлттэй хамт төлснөөр худалдан авалт баталгаажна.
- Нэг удаагийн худалдан авалтын доод дүн: 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг.

2.7.3. Хэрэглэгчийн түвшнээс хамаарч 2.7.2-т заасан шимтгэлд дараах хөнгөлөлтийг эдлүүлнэ:

- 2.7.3.1. **"Премиум" /Premium/ түвшин:** 0.1 хувиар ("8 хуваах" – 6.89 хувь, "10 хуваах" – 8.89 хувь);
- 2.7.3.2. **"Голд" /Gold/ түвшин:** 0.2 хувиар ("8 хуваах" – 6.79 хувь, "10 хуваах" – 8.79 хувь);
- 2.7.3.3. **"Платинум" /Platinum/ түвшин:** 0.3 хувиар ("8 хуваах" – 6.69 хувь, "10 хуваах" – 8.69 хувь).

2.7.4. Шимтгэлтэй бүтээгдэхүүний дагуу хийсэн худалдан авалтын буцаалт болон үнийн дүнгийн өөрчлөлтөд дараах нөхцөл хамаарна:

- 2.7.4.1. Худалдан авалт баталгаажсанаас хойш 14 (арван дөрөв) хоногийн дотор буцаалт хийсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл болон худалдан авалтын үндсэн үнийн дүнг бүрэн буцаан олгоно.
- 2.7.4.2. Худалдан авалт баталгаажсанаас хойш 14 (арван дөрөв) хоног өнгөрсний дараа буцаалт хийсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэлийг буцаан олгохгүй, харин худалдан авалтын үндсэн үнийн дүнг бүрэн буцаан олгоно.
- 2.7.4.3. Шимтгэлтэй бүтээгдэхүүний дагуу хийсэн худалдан авалтын үнийн дүнг өсгөх, бууруулах боломжгүй.
- 2.7.5. Хэрэглэгч дээрх шимтгэлтэй бүтээгдэхүүнийг ашиглан худалдан авалт хийсэн тохиолдолд тухайн худалдан авалтын хуваарьт төлбөрөөс төлсөн дүнтэй нь тэнцэх хэмжээгээр үйлчилгээний эрх нь буцаан сэргэнэ. Ингэснээр хэрэглэгч бүх төлбөрөө бүрэн төлж дуусахыг хүлээлгүйгээр, төлсөн дүнгийн хэмжээнд дахин худалдан авалт хийх боломжтой байна.

2.7.6. Хэрэглэгч шимтгэлтэй бүтээгдэхүүний хуваарьт төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд энэхүү үйлчилгээний нөхцөлийн 7-р бүлэгт заасан торгууль төлнө.

2.8. Хэрэглэгч дараах нөхцөлөөр хийсэн худалдан авалтад Дахин хуваалтын үйлчилгээг ашиглах боломжтой.

- Худалдан авалтын төлбөрөө урьдчилгаагүй 2 (хоёр) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 30 (гуч) хоногийн хугацаанд төлөх;
- Худалдан авалтын төлбөрөө 3 (гурав) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 30 (гуч) хоногийн хугацаанд төлөх;
- Худалдан авалтын төлбөрөө 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 45 (дөчин тав) хоногийн хугацаанд төлөх.
- Худалдан авалтын төлбөрөө урьдчилгаагүй 4 (дөрөв) хувааж 15 (арван тав) хоногийн зайтайгаар 60 (жар) хоногийн хугацаанд төлөх;
- Худалдан авалтын төлбөрөө 3 (гурав) хувааж 30 (гуч) хоногийн зайтайгаар 60 (жар) хоногийн хугацаанд төлөх;

2.8. Дахин хуваалтын үйлчилгээний шимтгэл нь тухайн худалдан авалтын төлөгдөөгүй төлбөрийн нийт үлдэгдлийн 4.99%-тай тэнцүү дүнтэй байна. Хэрэглэгч уг шимтгэлийг төлснөөр Дахин хуваалтын үйлчилгээ баталгаажна.

2.9. Дахин хуваалт баталгаажсанаар өмнөх төлбөрийн хуваарь хүчингүй болж, шинэчилсэн төлбөрийн хуваарь хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.10. Дахин хуваалтаар шинэчлэгдсэн төлөлтийн хуваарь нь үндсэн төлөлтийн хуваарийг уртасгасан нөхцөлөөр үүснэ.

- 2.11. Дахин хуваалтын хүсэлт баталгаажсаны дараа өөрчлөх, цуцлах, буцаах боломжгүй ба үйлчилгээний шимтгэлийг буцаан олгохгүй.
- 2.12. Хугацаа хэтрэлттэй эсхүл төлөгдөөгүй торгуультай худалдан авалтын хувьд хэрэглэгч уг төлбөр болон торгуулийг бүрэн төлсний дараа Дахин хуваалтын үйлчилгээг авах боломжтой.
- 2.13. Хэрэглэгч дахин хуваалтын дагуу үүссэн шинэчилсэн хуваарийн дагуу төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд энэхүү үйлчилгээний нөхцөлийн 7-р бүлэгт заасан торгууль төлнө.
- 2.14. Дахин хуваалтын үйлчилгээ нь шинэ худалдан авалт эсвэл шинэ зээлийн үйлчилгээ биш бөгөөд өмнө үүссэн төлбөрийн үүргийн нөхцөлийг өөрчилж буй хэлбэр болно.
- 2.15. Хэрэглэгч нь шинэчилсэн хуваарийн дагуу үүсэх бүх төлбөрийн үүрэг, хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 2.16. Стор пэй цахим мөнгөний үйлчилгээ:
- 2.16.1. Хэрэглэгч өөрийн нэр дээр системээс үүсгэсэн давтагдашгүй дугаар бүхий цахим мөнгөний дансаа цахим мөнгөний үйлчилгээнд ашиглана.
- 2.16.2. Цахим мөнгөний гэрээ байгуулаагүй Хэрэглэгч нь дараах нөхцөлөөр цахим мөнгөний үйлчилгээ авна.

Нэг өдрийн гүйлгээний дээд хязгаар	40,000 (дөчин мянга) төгрөг
Дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ	100,000 (нэг зуун мянга) төгрөг

- 2.16.3. Цахим мөнгөний гэрээ байгуулсан хэрэглэгч дараах нөхцөлөөр цахим мөнгөний үйлчилгээ авна.

Нэг удаагийн зарлагын гүйлгээний дээд хязгаар	5,000,000 (таван сая) төгрөг
Дансан дахь цахим мөнгөний дээд хэмжээ	20,000,000 (хорин сая) төгрөгөөс хэтрэхгүй
Нэг өдөрт хийх гүйлгээний хязгаар	Хязгааргүй (цахим мөнгөний хэмжээгээр хязгаарлагдана)

- 2.16.4. Хэрэглэгч Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгсэл ашиглан цахим мөнгөний дансаа цэнэглэх ба данс цэнэглэх доод хэмжээ 1,000 төгрөг байна.
- 2.16.5. Хэрэглэгч үйлчилгээний шимтгэлийг урьдчилан төлнө.

Гурав. Мерчантаас бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах

- 3.1. Төлбөрийн нэхэмжлэх үүсгэх хэмжээ:
- 3.1.1. Хэрэглэгч аппликейшнээр дамжуулан хийх нэг удаагийн худалдан авалтын дүн нь хамгийн багадаа 100,000 /нэг зуун мянга/-аас хамгийн ихдээ 15,000,000 /арван таван сая/ төгрөг хүртэл хэмжээтэй байна.
- 3.1.2. Хэрэглэгчид үйлчилгээний эрх үүсээгүй тохиолдолд шууд төлөлтөөр худалдан авалт хийж SPCFIN токены урамшуулал авах боломжтой.
- 3.2. Төлбөрийн нэхэмжлэх үүсгэх:
- 3.2.1. Мерчант дараах байдлаар төлбөрийн нэхэмжлэх үүсгэнэ.
- 3.2.1.1 Хэрэглэгчийн бүртгэлтэй гар утасны дугаараар үүсгэх нэхэмжлэх;
- 3.2.1.2 QR код бүхий нэхэмжлэх;
- 3.3. Нэхэмжлэхийн дагуу худалдан авалтын төлбөрийг төлөх:
- 3.3.1. Хэрэглэгч Мерчантаас бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахдаа аппликейшнд нэвтрэн эхний төлөлтийг төлснөөр худалдан авч буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээж авах боломжтой.

- 3.3.2 Шинэ хэрэглэгч эхний хоёр худалдан авалтыг хуваарийн дагуу амжилттай төлж дуусгасны дараа, дараагийн үйлчилгээнээс Компаниас тогтоосон үйлчилгээний эрхийн хэмжээнд давхар худалдан авалт үүсгэж ашиглах эрхтэй.
- 3.4. Төлбөрийн баримт авах:
- 3.4.1 Үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтын төлбөрийн баримтыг тухайн худалдан авалт хийсэн Мерчант олгоно.
- 3.5. Мерчантаас бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах:
- 3.5.1 Хэрэглэгчийн Компанийн үйлчилгээг ашиглан худалдан авсан бараа, үйлчилгээний чанар, стандарт, доголдлыг тухайн бараа, үйлчилгээг худалдаалж буй Мерчант хариуцах бөгөөд доголдолтой холбоотой асуудлыг Мерчанттай холбогдож шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Урамшуулал болон SPCFIN токен ашиглагдах үйлчилгээ

- 4.1. Хэрэглэгч худалдан авалтын төлбөрөө амжилттай төлж дуусгах бүрд тухайн худалдан авалтын үнийн дүнгээс хэрэглэгчийн түвшинд харгалзах дараах хувь хэмжээгээр SPCFIN токены урамшууллыг тооцож олгоно. Үүнд:
- “Энгийн” /Standard/ түвшинд 0.25 хувь;
 - “Премиум” /Premium/ түвшинд 0.5 хувь;
 - “Гоулд” /Gold/ түвшинд 0.6 хувь;
 - “Платинум” /Platinum/ түвшинд 0.7 хувь.
- 4.2. SPCFIN токен нь Стор пэй үндсэн үйлчилгээний салшгүй хэсэг биш ба урамшууллын шинжтэй виртуал хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө, хадгаламж, өгөөж гэх мэт санхүүгийн хэрэгсэлд тооцохгүй.
- 4.3. Компани нь зах зээлийн нөхцөл, хууль тогтоомжийн өөрчлөлт, зохицуулалтын шаардлага, дотоод бодлогоос хамааран SPCFIN токены урамшууллын хувь хэмжээ, нөхцөлийг өөрчлөх, түр зогсоох, эсхүл бүр мөсөн цуцлах эрхтэй.
- 4.4. Худалдан авалтын төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд тухайн худалдан авалтад SPCFIN токены урамшуулал бодогдохгүй.
- 4.5. SPCFIN токен ашиглагдах үйлчилгээ:
- 4.5.1. Хэрэглэгч Компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан, тусгай зөвшөөрөл бүхий виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид "Бирж" гэх) дэх өөрийн хэтэвчинд байршуулсан SPCFIN токеныг энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан хүрээнд ашиглах боломжтой.
- 4.5.2. “Премиум” /Premium/ түвшний хэрэглэгч 1,000,000 төгрөг хүртэлх, “Гоулд” /Gold/ түвшний хэрэглэгч 1,500,000 төгрөг хүртэлх, “Платинум” /Platinum/ түвшний хэрэглэгч 2,000,000 төгрөг хүртэлх үнийн дүнтэй худалдан авалтын төлбөрийг төлөхдөө өөрийн SPCFIN крипто хаяг дээр нийт үнийн дүнгийн 25 хувь болон түүнээс дээш хэмжээний SPCFIN токеноор цэнэглэх бөгөөд урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр 4 (дөрөв) хуваан 60 (жар) хоногийн хугацаанд төлөх эсвэл 2 (хоёр) хуваан 30 (гуч) хоногийн хугацаанд төлнө.
- 4.5.3. Хэрэглэгч боломжит SPCFIN токены төгрөгийн дүнг 4 дахин үржүүлсэнтэй тэнцэх худалдан авалтыг урьдчилгаа төлбөргүйгээр хийх боломжтой бөгөөд тухайн худалдан авалтын дүн 1,000,000 төгрөгөөс хэтрэхгүй Энэ тохиолдолд тухайн SPCFIN токен нь худалдан авалтаа амжилттай төлж дуустал түгжигдэнэ.
- 4.5.4. SPCFIN токен ашиглан үйлчилгээний эрхийг дараах нөхцөлөөр нээх болон нэмэгдүүлэх. Үүнд:
- 4.5.4.1. Хэрэглэгч өөрийн SPCFIN крипто хаяг дахь SPCFIN токеноор тухайн үеийн ханшаар тооцсон дүнгээр Үйлчилгээний эрх нь “Энгийн” /Standart/ түвшний хэрэглэгч 3,000,000 /гурван сая/ төгрөг хүртэл, “Премиум” /Premium/ түвшний хэрэглэгч 5,000,000 /таван сая/ төгрөг хүртэл, “Гоулд” /Gold/ түвшний хэрэглэгч

- 10,000,000 /арван сая/ төгрөг хүртэл, “Платинум” /Platinum/ түвшний хэрэглэгч 15,000,000 /арван таван сая/ төгрөг хүртэл үүсэх ба ханш өөрчлөгдөх бүрт тухайн үүссэн үйлчилгээний эрхийн хэмжээ өөрчлөгдөх боломжтой.
- 4.5.4.2. Хэрэглэгчийн SPCFIN крипто хаяг дахь түгжигдээгүй токены үнийн дүнтэй дүйцэхүйц дүнгээр үндсэн үйлчилгээний эрх нэмэгдэнэ. SPCFIN токены түгжигдээгүй хэмжээ болон ханшаас хамааран үйлчилгээний эрхийн хэмжээ өсч, буурах боломжтой бөгөөд ханшийн өөрчлөлтийг компани хариуцахгүй.
- 4.5.4.3. Хэрэглэгч SPCFIN токен ашиглан үйлчилгээний эрхээ нэмэгдүүлэх тохиолдолд Компани нь өөрийн дотоод дүрэм, журамд тухайн хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээлэл, худалдан авалтын мэдээлэлд нийцэж байгаа эсэхийг хянах эрхтэй бөгөөд үл нийцсэн тохиолдолд татгалзах эрхтэй.
- 4.5.5. SPCFIN токен ашиглан нэмэгдүүлсэн үйлчилгээний эрхийг дараах нөхцөлөөр бууруулна.
- 4.5.5.1. Хэрэглэгчийн SPCFIN крипто хаягт байгаа токены хэмжээ багассан тохиолдолд үйлчилгээний эрхийн хэмжээ тухайн багасгасан үеийн ханшийн хэмжээгээр буурна.
- 4.6. Компани нь Хэрэглэгчийн үйлчилгээний нөхцөлд заасан хүрээнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг урьдчилгаагүй худалдан авсан тохиолдолд үнийн дүнгийн 25%-тай дүйцэх хэмжээний SPCFIN токеныг түгжих бөгөөд хэрэглэгчийн SPCFIN-ээр нэмэгдсэн эрхийн хэмжээ тухайн дүнгээр буурна.
- 4.7. Тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрийг бүрэн төлж дууссанаар түгжигдсэн SPCFIN токеныг чөлөөлнө.
- 4.8. Хэрэглэгч SPCFIN токеныг дээрх хэлбэрээр Компанийн үйлчилгээнд ашиглаж буйн төлөө аливаа шимтгэл, хураамж */Бирж үйлчилгээ үзүүлсний төлөө хэрэглэгчээс авах үйлчилгээний шимтгэл үүнд хамаарахгүй/-ийг* Компанид төлөхгүй.
- 4.9. Хэрэглэгч өөрийн эзэмшлийн SPCFIN токеныг Компанийн үйлчилгээнд ашиглах эсэх шийдвэр гаргахад мэдээлэл өгөх зорилгоор аппликейшн дээр SPCFIN токены ханшийн мэдээлэл, SPCFIN токены үлдэгдлийн мэдээллийг нээлттэй харуулж болно.
- 4.10. Хэрэглэгч SPCFIN токены шилжүүлэг хийх нь өөрийн санаачилга, шийдвэр байх бөгөөд, буруу блокчэйн сүлжээ, алдаатай хаяг руу шилжүүлэг хийсэн тохиолдолд компани тухайн токеныг сэргээх, шилжүүлгийг буцаах боломжгүй тул үүсэх эрсдэлийг хэрэглэгч хариуцна.
- 4.11. Хэрэглэгч өөрийн SPCFIN крипто хаягаас SPCFIN токены зарлага гаргах тохиолдолд гүйлгээ бүрд зарлагын дүнгээс үл хамааран 5,000 /таван мянга/ SPCFIN токены шимтгэлтэй байна. Энэхүү шимтгэлийг хэрэглэгчийн зарлага гаргаж буй SPCFIN токены нийт дүнгээс автоматаар суутган тооцож, шимтгэлийг суутгасны дараах үлдсэн SPCFIN токенг хүлээн авагчийн крипто хаяг руу шилжүүлнэ.
- 4.12. Компани Сэжигтэй, өндөр дүнтэй, олон давтамжтай SPCFIN токены шилжүүлэг илэрсэн тохиолдолд тухайн шилжүүлгийг түр хугацаагаар хязгаарлах, шалгах, зогсоох эрхтэй.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 5.1. Хэрэглэгч нь энэхүү үйлчилгээний нөхцөл хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Компаниас тогтоосон үйлчилгээний эрхийн хэмжээнд ашиглах болон хуваан төлөлтөө сонгосон хуваарийн дагуу төлөх үүргийг хүлээнэ.
- 5.2. Хэрэглэгч аппликейшнд хувийн болон санхүүгийн мэдээллээ үүсгэх, эсхүл илгээх, дамжуулахдаа дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 5.2.1. Хуурамч мэдээлэл оруулахгүй байх;
- 5.2.2. Бусдын хувийн болон санхүүгийн мэдээллийг оруулахгүй байх;
- 5.2.3. Хугацаа дуусгавар болсон бичиг баримтын мэдээлэл оруулахгүй байх.
- 5.3. Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөлийн 5.2-т заасныг зөрчин мэдээлэл оруулсан бол Компани нь хэрэглэгчийн үйлчилгээний эрх нээлгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

- 5.4. Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөлийн 5.2-т заасныг зөрчин өөрийн хууль бус үйлдлийн улмаас тухайн мэдээллийн өмчлөгч, эзэмшигч болон Компанид учруулсан аливаа гэм хор, хохирлыг бүрэн хариуцна.
- 5.5. Компанийн систем, программаас үүдэлтэй доголдол гарснаас худалдан авалт амжилтгүй болсон, төлбөр төлөлт саатсан зэргээс болж хэрэглэгч үйлчилгээ авч чадаагүй тохиолдолд энэ талаар 76110111 дугаарт, албан ёсны Storepay нэртэй facebook хуудасны чат, эсвэл customer_voice@storepay.mn и-мэйл хаягт нэн даруй мэдэгдэж, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй байна. Тухайн гомдлыг ажлын 5 хүртэлх өдрийн дотор хянан шийдвэрлэж, хэрэглэгчид хариу мэдэгдэнэ.
- 5.6. Хэрэглэгч нь өөрийн санхүүгийн чадамжид тохируулан худалдан авалт хийж, худалдан авалтын төлбөрийг хуваарьт төлөлтийн дагуу цаг тухайд нь бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 5.7. Хэрэглэгч банк, банк бус санхүүгийн байгууллага, гуравдагч этгээдээс авсан зээлийн эргэн төлөлт хийх үүрэг хүлээсэн үйлчилгээний хэрэглээгээ тооцоолж, худалдан авалтыг хийх үүрэг хүлээнэ.
- 5.8. Хэрэглэгч нь аппликейшнд нэвтрэх нэр, нууц үг болон худалдан авалт баталгаажуулах, цахим мөнгөний гүйлгээ хийх пин кодоо нууцлах мөн бусад этгээд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх, цахим шуудан, мессеж, гар утсаар өөрийн нууц мэдээллийг задруулахгүй байх, өөрөөс хамаарах арга хэмжээг авч мэдээллийн нууцлалаа чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд нууцлалаа алдсанаас үүсэх хариуцлагыг хэрэглэгч өөрөө хүлээнэ.
- 5.9. Хэрэглэгч нь өөрийн аппликейшнд нэвтрэх нэр болон нууц үгийн нууцлал, худалдан авалт баталгаажуулах, цахим мөнгөний гүйлгээ хийх пин код зэрэг мэдээллийн нууцлалыг өөрийн эцэг эх, эхнэр/нөхөр, хүүхэд болон бусад гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар задруулсан, дамжуулсан эсхүл ашиглуулсны улмаас үүсэх үр дагаврыг хэрэглэгч өөрөө хариуцна.
- 5.10. Хэрэглэгчид дараах үйлдлийг хориглоно. Үүнд:
 - 5.10.1. Өөрийн хувийн болон санхүүгийн мэдээлэл, аппликейшнд нэвтрэх бүхий л мэдээллийг гуравдагч этгээдэд ашиглуулах, үйлчилгээний эрх нээлгэх зорилгоор дамжуулах, үйлчилгээний эрхийг бусдад зарах, ашиглуулах, бэлэн мөнгө болгох;
 - 5.10.2. Бусдын хувийн болон санхүүгийн мэдээлэл ашиглах, хуурамч мэдээлэл оруулах, хугацаа дууссан эсхүл хуурамч баримт бичиг ашиглах;
 - 5.10.3. Системийн хэвийн үйл ажиллагаанд халдах оролдлого хийх, доголдол үүсгэх, дизайн, ноу-хауг хуулбарлах, задлах, өөрчлөх;
 - 5.10.4. Олон нийтийн хэрэгслээр худал, төөрөгдөл үүсгэх мэдээлэл тараах замаар Компани, мерчант болон бусдад хохирол учруулах.
- 5.11. Дээрх 5.10-д заасан хориглосон үйлдлээс үүдэн компани, мерчант болон гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирол, үр дагаврыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 5.12. Хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үг, худалдан авалт баталгаажуулах, цахим мөнгөний гүйлгээ хийх пин код зэргийг ашиглан хийгдэж буй аливаа худалдан авалт, гүйлгээг эрх эзэмшигч буюу тухайн хэрэглэгч өөрөө хийж буйд тооцох ба үйлчилгээний эрх, нэвтрэх мэдээлэл, хувийн мэдээллээ гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүйгээр алдсан, дамжуулсан, эсхүл ашиглуулсан нь өр төлбөр, хураамж, торгууль, зээлийн мэдээллийн ангилал буурах, эрх хязгаарлагдах зэргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 5.13. Хэрэглэгч Стор пэй аппликейшнд нэвтрэх нэр болон нууц үг, цахим мөнгөний гүйлгээ хийх пин код зэрэг мэдээллийг хамгаалах үүргээ биелүүлээгүй, бусдад санаатайгаар шилжүүлсэн, алдсан, залилуулсан, гуравдагч этгээд ашигласан тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй болно.
- 5.14. Хэрэглэгч нь гүйлгээ хийхдээ дансны дугаар, гүйлгээний утга, гүйлгээний дүнгээ зөв оруулах бөгөөд буруу оруулсны улмаас үүсэх зардал, аливаа хохирлыг өөрөө хариуцна.

- 5.15. Хэрэглэгч нь аппликейшныг суулгасан гар утас эсхүл төхөөрөмжөө бусдад дамжуулсан, ашиглуулсан, хэрэглүүлсэн, эвдэрсэн эсхүл бүртгэлтэй утасны дугаарын орох болон гарах ярианы эрх хаагдсан, сүлжээнээс гарсны улмаас хохирол учирсан бол гарсан зардал, хохирлыг бүрэн хариуцна.
- 5.16. Хэрэглэгч гар утас, төхөөрөмжөө гээгдүүлсэн, алдсан, Стор пэй аппликейшнд нэвтрэх нэр, нууц үг, баталгаажуулах, цахим мөнгөний гүйлгээ хийх пин код зэргийг гуравдагч этгээд мэдсэнээр эрх олгогдоогүй, маргаантай болон луйврын шинжтэй гүйлгээ хийгдсэнийг мэдсэн тохиолдолд өөрөөс шалтгаалах нэр, нууц үгийг өөрчлөх арга хэмжээг авах, Компанид нэн даруй мэдэгдэж, өөрийн бүртгэлийг түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.
- 5.17. Хэрэглэгчийн алдаатай худалдан авалт хийсэн, үйлчилгээний нөхцөлийг бүрэн ойлгоогүй гэх зэрэг хэрэглэгчийн илтэд хайхрамжгүй, болгоомжгүй үйлдэлтэй холбоотой үр дагаврыг Компани хариуцахгүй.
- 5.18. Хэрэглэгч нь хууль тогтоомж болон үйлчилгээний нөхцөлийн холбогдох заалтуудыг зөрчсөнөөс үүсэх хохирол, аливаа үүргийг дангаар хариуцах үүрэгтэй бөгөөд Компани хариуцахгүй болно.
- 5.19. Зээлийн мэдээллийн сан болон зээлжих зэрэглэлийн онооны лавлагааны төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 5.20. Хэрэглэгч өөрийн үйлчилгээний эрхийн хэмжээ, Стор пэй аппликейшнд нэвтрэх нэр болон нууц үг, худалдан авалт баталгаажуулах пин код зэрэг мэдээллийг бусдад санаатайгаар шилжүүлсэн, алдсан, залилуулсан, гуравдагч этгээд ашигласан гэх үндэслэлээр өр төлбөрөөс татгалзах эрхгүй бөгөөд нэн даруй төлбөрөө төлж Компанийг хохиролгүй болгох үүрэгтэй.
- 5.21. Компаниас үзүүлж буй үйлчилгээний төрлөөс хамаарч аливаа төлбөр тооцоо төлөх шаардлага бий болсон тохиолдолд үүнийг хэрэглэгч хариуцаж төлнө.
- 5.22. Хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээлэлд системийн доголдлоос үүдэлтэй эсхүл өөрөө өөрчлөөгүй байсан ч өөрчлөгдсөн байгааг мэдсэн даруй компанийн customer_voice@storepay.mn и-мэйл хаяг болон 76110111 гэсэн дугаарт яаралтай мэдэгдэж солиулах үүрэгтэй.
- 5.23. Энэхүү үйлчилгээний нөхцөл буюу хэлцэлд дурдагдаагүй хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Зургаа. Компанийн эрх, үүрэг

- 6.1. Хэрэглэгчээс үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг хүлээн авч, ашиглах, боловсруулах, хадгалах, цуглуулах, дамжуулах эрхтэй.
- 6.2. Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг шалгаж, хиймэл оюун ухааны тусламжтайгаар дүн шинжилгээ хийх, тэдгээрийн үнэн зөвийг шалгаж, хянаж баталгаажуулах эрхтэй.
- 6.3. Хэрэглэгчийн үүсгэсэн, дамжуулсан хувийн болон санхүүгийн мэдээллийг ашиглан үйлчилгээний эрхийн хэмжээг тодорхойлох эрхтэй.
- 6.4. Компани дотоод бодлого, дүрэм журмын дагуу хэрэглэгчид үүсгэсэн үйлчилгээний эрхийг нэмэгдүүлэх, бууруулах эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлт нь хэрэглэгчийн эрсдэлийн түвшинд үндэслэн системд автоматаар тооцоологдоно.
- 6.5. Хэрэглэгчийн худалдан авалтын хуваарьт төлөлттэй холбоотой мэдээллийг Зээлийн мэдээллийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмын дагуу ангилж, зээлийн мэдээллийн санд нийлүүлэх эрхтэй.
- 6.6. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасны дагуу цуглуулсан мэдээллийг Компани дотоод хэрэгцээ, харилцагчийг таньж мэдэхэд ашиглах эрхтэй.
- 6.7. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан журмын дагуу цуглуулсан мэдээллийг аппликейшн болон түүний хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд ашиглах эрхтэй.

- 6.8. Энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан журмын дагуу хэрэглэгчийн зөвшөөрлөөр цуглуулсан мэдээллийг Компанийн аппликейшныг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор хөгжүүлэгч Компанид дамжуулах, шилжүүлэх, ашиглуулах эрхтэй.
- 6.9. Компани хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэр, зохицуулагчийн шаардлага, мөн үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг хангах зорилгоор Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах, шинэчлэх эрхтэй.
- 6.10. Олон давтамжтай, өндөр дүнтэй мөнгөн болон токен хэлбэрээр гүйлгээ орж гарсан болон компаниас сэжигтэй гэж үзсэн бусад тохиолдолд хэрэглэгчийг баталгаажуулах зорилгоор эрхийг зогсоож, шалгах эрхтэй.
- 6.11. Хэрэглэгч нь аппликейшныг дараах зорилгоор ашигласан тохиолдолд **урьдчилан сануулалгүйгээр** үйлчилгээний эрхийг дахин ашиглах боломжгүйгээр хязгаарлах буюу үйлчилгээг ашиглах эрх, цахим мөнгөний гүйлгээ хийх эрхийг зогсоож, хаана. Үүнд:
- 6.11.1. Зүй бусаар эсхүл хууль бус зорилгоор ашигласан, ашиглахыг завдсан;
 - 6.11.2. Сэжигтэй гүйлгээ, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашигласан;
 - 6.11.3. Зориулалтын бусаар ашигласан;
 - 6.11.4. Бусдын хувийн мэдээллийг зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй ашигласан;
 - 6.11.5. Гуравдагч этгээдэд ашиглуулсан, ашиглуулахаар завдсан тохиолдолд;
 - 6.11.6. Залилах, хууран мэхлэх, худал мэдээлэлд ашигласан;
 - 6.11.7. Олон нийтийн хэрэгслээр худал, төөрөгдөл үүсгэх мэдээлэл тараахад ашигласан;
 - 6.11.8. Зүй зохисгүй байдлаар, бусдад хохиролтойгоор ашигласан тохиолдолд.
- 6.12. Хэрэглэгч аппликейшныг дээрх зорилгоор ашигласан талаар хуулийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж шалгуулж, шийдвэрлүүлэх эрхтэй.
- 6.13. Хэрэглэгч үйлчилгээний эрхээ бусдад зарсан, зарахыг завдсан, хувийн мэдээллээ бусдад ашиглуулахыг хориглох бөгөөд компани үйлчилгээний эрхийг урьдчилан сануулалгүйгээр хаах эрхтэй.
- 6.14. Системд үүссэн доголдол, өөр хүний болон буруу, худал мэдээлэл ашиглаж мөн үүнтэй адилтган үзэх, өөр бусад шалтгаанаар аппликейшны шинэ хэрэглэгч болсон тохиолдолд Компани нь мэдсэн даруй тухайн хэрэглэгчийн эрхийг хааж шалгах, идэвхтэй худалдан авалт байгаа бол тухайн худалдан авалтын төлбөрийг нэн даруй хэрэглэгчээс бүрэн төлж дуусгахыг шаардах эрхтэй.
- 6.15. Компани нь Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан хориглох, хязгаарлах, зогсоох, хаах арга хэмжээ авагдсан, эсхүл шалгагдаж байгаа тохиолдолд дахин эрх үүсгэхгүй, нэмж худалдан авалт хийлгэхгүй байх эрхтэй.
- 6.16. Компани нь системийн хэвийн үйл ажиллагаанд халдах (хакердах) үйлдэл, оролдлого хийсэн хэрэглэгчийн эрхийг дахин ашиглах боломжгүйгээр хаах, хязгаарлах эрхтэй.
- 6.17. Хэрэглэгч нь хууль тогтоомж болон үйлчилгээний нөхцөлийн холбогдох заалтуудыг зөрчсөн, зөрчихийг завдсан гэж үзсэн тохиолдолд үйлчилгээг ашиглах эрхийг урьдчилан сануулалгүйгээр зогсоох, хаах, шалгах эрхтэй.
- 6.18. Компанийн буруутай үйл ажиллагаа, эсхүл Компанийн хяналтад буй системийн доголдлоос шууд шалтгаалан хэрэглэгчид бодит хохирол учирсан нь хууль ёсны баримтаар нотлогдсон тохиолдолд Компанийн хариуцлага нь зөвхөн тухайн худалдан авалтын дүнгээр хязгаарлагдах бөгөөд шууд бус, дам болон алдагдсан ашигтай холбоотой аливаа хохирлыг Компани хариуцахгүй.

Долоо. Худалдан авалтын хугацаа хэтрэлт

- 7.1. Хэрэглэгч та энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан бүх төрлийн үйлчилгээний хэрэглэгч болсноор худалдан авалтын төлбөрөө хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах үүрэг хүлээнэ.
- 7.2. Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан хуваан төлөх үйлчилгээний хуваарьт төлбөр төлөх үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд төлөх ёстой төлбөр дээр торгууль нэмэгдэж бодогдоно.

7.3. Хэрэглэгч хуваарьт төлөлтийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн өдрөөс эхлэн хугацаа хэтрүүлсэн нэхэмжлэхийн дүнгээс хамаарч дараах байдлаар торгуулийг хуваарьт төлөлт дээр нэмнэ. Үүнд:

- 125,000 төгрөг хүртэлх нэхэмжлэхийн дүнд 5,000 төгрөг;
- 125,001 төгрөгөөс 250,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 10,000 төгрөг;
- 250,001 төгрөгөөс 375,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 15,000 төгрөг;
- 375,001 төгрөгөөс 500,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 20,000 төгрөг;
- 500,001 төгрөгөөс 625,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 25,000 төгрөг;
- 625,001 төгрөгөөс 750,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 30,000 төгрөг;
- 750,001 төгрөгөөс 875,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 35,000 төгрөг;
- 875,001 төгрөгөөс 1,000,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 40,000 төгрөг;
- 1,000,001 төгрөгөөс 1,125,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 45,000 төгрөг;
- 1,125,001 төгрөгөөс 1,250,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 50,000 төгрөг;
- 1,250,001 төгрөгөөс 1,375,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 55,000 төгрөг;
- 1,375,001 төгрөгөөс 1,500,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 60,000 төгрөг;
- 1,500,001 төгрөгөөс 1,625,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 65,000 төгрөг;
- 1,625,001 төгрөгөөс 1,750,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 70,000 төгрөг;
- 1,750,001 төгрөгөөс 1,875,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 75,000 төгрөг;
- 1,875,001 төгрөгөөс 2,000,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 80,000 төгрөг;
- 2,000,001 төгрөгөөс 2,125,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 85,000 төгрөг;
- 2,125,001 төгрөгөөс 2,250,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 90,000 төгрөг;
- 2,250,001 төгрөгөөс 2,375,000 төгрөг бүхий нэхэмжлэхийн дүнд 95,000 төгрөг;
- 2,375,001 төгрөгөөс дээш нэхэмжлэхийн дүнд 100,000 төгрөг.

7.4. Хэрэглэгч хуваарьт төлөлт болон торгуулиа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн 8 дахь хоногоос 7 хоног тутам 7.3-т заасан хэмжээгээр торгууль дахин нэмэгдэнэ.

7.5. Торгууль нь худалдан авалтын үлдэгдэл үнийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй.

7.6. Хэрэглэгч хуваарьт төлбөрийг хэсэгчилж төлсөн тохиолдолд эхний ээлжид 7.3, 7.4-н дагуу бодогдсон торгууль, үлдсэн дүнгээс тухайн хуваарьт төлөлтийг суутгана.

7.7. Төлбөр төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Үйлчилгээний эрхийг тухайн төлөлтийг бүрэн төлөх хүртэл хугацаагаар зогсоох бөгөөд төлөлт хийснээр Үйлчилгээг үргэлжлүүлэн ашиглах эрхтэй болно.

7.8. Энэхүү үйлчилгээний нөхцөлийн 7-р бүлэгт заасан Хуваарьт төлөлтийн хугацааг хэтрүүлсэн хоног, авагдсан арга хэмжээнээс хамаарч 7.7-г үл харгалзан үйлчилгээний эрхийг түр зогсоох, хаах, дахин ашиглуулахгүй байх шийдвэрийг Компани дангаар шийдвэрлэнэ.

7.9. Хэрэглэгч худалдан авалтын буцаалт хийх үед Мерчантаас хэрэглэгчийн худалдан авалтын буцаалтын хүсэлтийг ирүүлэхээс өмнө бодогдсон торгуулийг 7.3, 7.4-т заасан хэмжээгээр суутган үлдэгдэл төлбөрийг хэрэглэгч аппликейшнд банкны дансаа холбосон тохиолдолд ажлын 48-72 цагт багтаан хэрэглэгч рүү шилжүүлнэ.

7.10. Хэрэглэгч худалдан авалтын буцаалт хийх үед Мерчантаас хэрэглэгчийн худалдан авалтын буцаалтын хүсэлтийг ирүүлснээс хойш бодогдсон торгуулийг суутгахгүйгээр төлбөрийг хэрэглэгч рүү шилжүүлнэ.

7.11. Хэрэглэгчийн идэвхтэй худалдан авалтын үнийн дүн өсч, хүсэлт ирж баталгаажуулсан тохиолдолд төлсөн буюу баталгаажсан байгаа хуваарьт төлөлтийн зөрүү дүнг хүсэлт баталгаажсанаас хойш 48 цагийн дотор төлөөгүй тохиолдолд торгууль бодогдоно.

7.12. Хэрэглэгч төлбөр төлөх хугацаагаа хэтрүүлсэн тохиолдолд Компани нь холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэглэгчийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулан нийлүүлэх эрхтэй бөгөөд хэрэглэгч уг бүртгэлтэй холбоотой маргаан гаргахгүй.

Найм. Үйлчилгээний эрсдэл

- 8.1. Хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээлэл, худалдан авалтын түүхэд үндэслэж үйлчилгээний эрхийн хэмжээг тогтоох бөгөөд энэ нь хэрэглэгчийг аливаа өрийн дарамтад оруулахгүй гэх баталгаа болохгүй.
- 8.2. SPCFIN токентд суурилсан виртуал хөрөнгийн үйлчилгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн виртуал хөрөнгийн бирж үзүүлэх ба уг биржээс авч буй виртуал хөрөнгийн үйлчилгээ болон SPCFIN токен нь виртуал хөрөнгө болохын хувьд гарах аливаа эрсдэлийг Компани хариуцахгүй.

Ес. Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал ба хэрэглэгчийн санал, хүсэлт

- 9.1. Компани нь Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын олон улсын ISO/IEC 27001:2022 стандартыг хэрэгжүүлэн ажилладаг ба үйлчилгээнд бүртгүүлэх, аппликейшнд нэвтрэх, үйлчилгээ авах явцад Хэрэглэгч болон түүний хандалтын талаарх тодорхой мэдээлэл, бичиг баримтууд болон хэрэглэгчийн хувийн мэдээллийг Компанийн Нууцлалын бодлогын дагуу цуглуулж, боловсруулж, хадгалж, ашиглана.
- 9.2. Энэхүү үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, хэрэглэгчээр бүртгүүлж үйлчилгээг ашиглаж байгаа нь хэрэглэгчийн хувийн мэдээллийг Нууцлалын бодлогод заасны дагуу ашиглахыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 9.3. Хэрэглэгч customer_voice@storepay.mn и-мэйл хаягаар, албан ёсны нийгмийн сүлжээний сувгууд болон 76110111 дугаарын утсаар долоо хоногийн бүх өдрүүдэд 09:00-22:00 цагийн хооронд Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах болон санал, хүсэлт, гомдол гаргах боломжтой.

Арав. Холбоос

- 10.1. Аппликейшнд Мерчант эсхүл Компанитай хамтран ажиллагч гуравдагч этгээдийн вэбсайтын холбоосыг мэдээллийн эсхүл сурталчилгааны зорилгоор байрлуулж болох бөгөөд эдгээр вэбсайт нь Компанийн хяналтаас гадуур байх тул тэдгээр гуравдагч талын вэбсайт дээрх аливаа контенттой холбоотойгоор Компани үүрэг, хариуцлага хүлээхгүй.

Арван нэг. Үйлчилгээний оюуны өмчийн хамгаалалт

- 11.1. Хэрэглэгч нь Контентыг Компанийн урьдчилан олгосон бичгийн зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй бөгөөд Компанитай өрсөлдөх зорилгоор, эсхүл Компанийн хэвийн үйл ажиллагаа, нэр хүнд, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах санаа, зорилгоор Контентод аливаа хяналт тавих, ашиглах, хуулбарлах, өөрчлөх, худалдах, түгээх, дамжуулах эсхүл бусад хэлбэрээр зүй зохисгүй ашиглахыг хориглоно.
- 11.2. Энэ үйлчилгээний нөхцөлийн дагуу аппликейшнийг ашиглахаас бусад тохиолдолд хэрэглэгч нь Контентод хамаарах аливаа төрлийн эрх эдлэхгүй.
- 11.3. Компанийн оюуны өмчид хамаарах заалтыг хэрэглэгч зөрчсөн тохиолдолд түүний үр дагаварт учирсан хохирол, нөхөн төлбөрийг хэрэглэгч хариуцна.

Арван хоёр. Хүчин төгөлдөр болох

- 12.1. Хэрэглэгч үйлчилгээний нөхцөлтэй танилцаж, бүрэн ухамсарлаж ойлгож хүлээн зөвшөөрснөөр тус хэлцэл хүчин төгөлдөр болно.

-СТОП ПЭЙ ББСБ ХХК-